

## БОНДЫН ЗАХ ЗЭЭЛ

Та энэ хичээлийг судалснаар

- Бондын тухай үндсэн ойлголт
  - Бондын үндсэн параметрууд
  - Бондын төрлүүд, бонд гаргахын ач холбогдол
  - Бондын үнэлгээ, өгөөж
- зэрэг ойлголтуудыг авах болно.

### 1. Бондын тухай үндсэн ойлголт

Монгол улсын “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуульд “Өрийн бичиг гэж тодорхой хугацааны дараа үндсэн төлбөр болон хүүг мөнгөн, эсвэл эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн хэлбэрээр эргүүлэн төлөхийг гэрчилсэн үнэт цаас” гэж тодорхойлсон байна. Өөрөөр хэлбэл “өрийн бичиг” буюу бонд гэдэг нь бусдаас тодорхой нөхцлөөр мөнгө зээлж буйг гэрчилсэн үнэт цаас юм. Хэдийгээр хуульд “өрийн бичиг” гэсэн нэр томъёо хэрэглэгдэж байгаа боловч олон улсын төвшинд “бонд” хэмээх нэрийг түгээмэл хэрэглэдэг, Монголын зах зээлд ч энэхүү нэр томъёо танил болсон тул “БОНД” гэсэн нэрээр цаашид энэхүү сургалтын материалд орох болно.

Бонд гаргаснаар бусдаас тодорхой хэмжээний мөнгийг зээлж буй учраас энэхүү зээлийн буюу бондын хугацаа, хүүний тухай ойлголт гарч ирнэ. Иймд дээрх 2 ойлголт болон бондтой холбоотой бусад нэр томъёоны талаар тодруулан авч үзье.

- Бондын нэрлэсэн үнэ:

Бондыг хөрөнгийн зах дээр нийтэд арилжих зорилгоор бондын үнэ гэсэн ойлголт гарна. Хэрэв аливаа компани банкнаас зээл авсан бол тухайн компани болон зээл олгож буй банкны хооронд зээлийн нийт дүнг тусгасан гэрээ хийдэг. Харин компани энэхүү зээлээ хөрөнгийн зах зээлээс татахаар бонд гаргасан бол тухайн бондыг худалдан авагч нь дээртхтэй адил зөвхөн ганц банк байхгүй, хэдэн арван байгууллага, хувь хүмүүс худалдан авах боломжтой учраас бондоо нэрлэсэн үнээр гаргана. Жишээ нь: А компани жилийн 15 хувийн хүүтэй нийт 1 тэрбум төгрөгийн үнэ бүхий бонд гаргасан тохиолдолд нэрлэсэн үнэ нь 1000 төгрөгийн (нэрлэсэн үнийг компани өөрөө тогтооно) үнэтэй 1 сая ширхэг бонд гаргана гэсэн үг. ( $1000 \text{ төг} \times 1\,000\,000 = 1\,000\,000\,000 \text{ төгрөг}$ ) Ингэснээр 1000 төгрөгтэй иргэн тухайн компанийн 1 ширхэг бондыг худалдан авч өөрийн 1000 төгрөгийг жилийн 15 хувийн хуутэйгээр зээлдүүлэх боломжтой болно.

Энэхүү компаниас тогтоосон үнийг нэрлэсэн үнэ буюу face value (мөн par value) гэдэг.

- Бондын зах зээлийн үнэ:

Бонд нь хөрөнгийн зах зээлд буюу бирж дээр арилжигддаг тухай дээр дурдсан. Урт хугацаанд зах зээлийн хүүгийн өөрчлөлтөөс хамааран бондын үнэ бирж дээр анхны нэрлэсэн үнээсээ дээш доош өөрчлөгдөж байдаг. Энэхүү бирж

дээрх үнийг бондын зах зээлийн үнэ гэнэ. Жишээ нь: Хэрэв зах зээлийн хүүгийн норм буурвал тухайн бондын хүүгээс олох өгөөж нь бусад зээлийн хүүгийн орлогоос өндөрт тооцогдож энэхүү бондыг худалдан авах эрэлт нэмэгдсэнээр бондын зах зээлийн үнэ өснө.

- Бондын хүү:

Энэ нь тухайн бондоор дамжуулан зээлүүлсэн мөнгөндөө таны ирээдүйд авах хүүгийн хувь хэмжээ юм. Дээрх жишээнд дурдсан А компанийн бондын 1 жилийн хүү 15 хувь гэж үзвэл  $1000 * 15 / 100 = 150$  төгрөгийн хүүг 1 жилийн хугацаанд хүртэнэ.

- Бондын дуусгавар хугацаа:

Аливаа зээл тодорхой хугацаатай байдаг. Хугацаа дуусахад анх зээлдүүлсэн мөнгөө буцаан төлөх үүрэгтэй. Бондын хувьд энэ хугацааг бондын дуусгавар хугацаа буюу maturity date хэмээн нэрлэдэг.

- Бондын хүү төлөгдөх хугацааны үечлэл:

Аливаа хөрөнгө оруулалтад түүнээс олох орлогын хугацаа ихээхэн чухал хүчин зүйлд тооцогддог. Тухайлбал та жилд нэг удаа хүү бодох банкинд мөнгөө хадгалуулснаас жилд 2 удаа хүү бодох банкинд хадгалуулвал эхний хүүгийн орлогоор дахин хөрөнгө оруулалт хийж, хүүгийн хүү хүртэх боломжтой болно. Энэхүү хугацааг бондын хүү төлөгдөх хугацааны үечлэл гэх бөгөөд ихэвчлэн 6 сарын хугацаатай байдаг байна.

## **2. Бондын төрлүүд, ач холбогдол**

Үнэт цаас гаргагчийн хувьд бондыг

- Засгийн газрын
- Орон нутгийн засаг захиргааны
- Компанийн гэж ангилдаг.

### *2.1 Засгийн газрын бонд:*

Засгийн газар төсвийн алдагдлыг нөхөх, томоохон хөрөнгө оруулалтын төслүүд хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр татах зорилгоор бонд гаргадаг. Хэдийгээр үндсэн зорилго нь санхүүжилтийн эх үүсвэр татахад оршиж байгаа мэт боловч Засгийн газрын үнэт цаас нь нийт эдийн засагт олон чухал үүрэг гүйцэтгэдэг. Тухайлбал:

- Засгийн газрын үнэт цаасаар дамжуулан төрөөс мөнгөний оновчтой бодлогыг хэрэгжүүлдэг. Тодруулж хэлбэл Засгийн газрын үнэт цаасны зах зээлийг удирдах замаар төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх нэн чухал хэрэгсэл болдог.

- Засгийн газрын үнэт цаас нь маш бага эрсдэлтэй гэж нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн байдаг учраас түүнийг худалдан авах эрэлт хөрөнгийн, мөнгөний захын аль алинд нь бий болдог. Гол нь ийм эрсдэл багатай өрийн хэрэгсэл нь санхүүгийн зах зээлд хөрөнгөө байршуулж байгаа бүх оролцогчдод нийт хөрөнгийн эрсдлийг хуваарилах өргөн боломж бий болгодог. Тэгээд ч зогсохгүй захын ерөнхий хөдөлгөөнийг илэрхийлэх дохиолол болж өгдөг. Өөрөөр хэлбэл үнэт цаасуудын үнэ хүчтэй өөрчлөгдөх магадлалтай тодорхой бус байдал бий болоход хөрөнгө оруулагчид засгийн газрын үнэт цаасанд хөрөнгөө шилжүүлнэ гэсэн үг юм. Нөгөөтэйгүүр ийм төрлийн үнэт цаас зах зээлийн хөгжил сул орны хувьд зах зээлийн харилцааг тогтооход эхний ээлжинд идэвхитэй хэрэгсэл болон хэрэглэгддэг юм.

### *2.2 Орон нутгийн засаг захиргааны бонд:*

Орон нутгийн засаг захиргааны бондын тухайн аймаг нийслэлийн иргэдийн хурлын зөвшөөрлөөр Засаг дарга гаргана.

Тухайн орон нутагт хэрэгжүүлэхээр төлөвлөж буй томоохон төслийг санхүүжүүлэх, орон нутгийн төсвийг санхүүжүүлэх зэрэг зорилгоор гаргадаг бөгөөд орон нутгийн төсвийн орлогоор баталгаажсан байдаг. Түүнчлэн энэ төрлийн бондоос олж буй ашиг орлого нь тухайн орон нутгийн татварын орлогоос чөлөөлөгдсөн байдгаараа онцлогтой, харьцангуй эрсдэл багатай үнэт цаас юм.

### *2.3 Компанийн бонд:*

Бондыг хүүгийн хэлбэрээс нь хамааруулж энгийн, хямдруулсан, хөвөгч хүүтэй гэж ангилна.

Нэрлэсэн үнээс хүүгийн төлбөрийг хасч хямдруулсан үнээр арилжих нь бондыг хямдруулсан (тэг хүүтэй буюу zero coupon bond) бонд, инфляциас хамааруулан тодорхой хугацаанд хүүгийн хувь хэмжээ өөрчлөгдөж байсвал хөвөгч хүүтэй (floated rate bond) бонд гэж нэрлэнэ.

- Эргэн дуудах эрхтэй бонд:

Бондын дуусгавар хугацаа болохоос өмнө шаардлагатай гэж үзвэл компани бондоо эргүүлэн дуудаж болно. Энэ нь бондын хугацаа дуусахаас өмнө үндсэн төлбөрийг хийж тооцоо дуусгахыг хэлнэ. Жишээ нь: А компанийн 10 жилийн хугацаатай гаргасан бонд жилийн 15 хувийн хүүтэй байтал 5 жилийн дараа зах зээлийн хүүгийн хэмжээ буурч компанид өөр эх үүсвэрээс жилд 10 хувийн хүүтэйгээр мөнгө татах боломж бий болсон тохиолдолд өмөн гаргасан бондоо буцаан дуудаж, төлбөрийг хийгээд 10 хувийн хүүтэй бондоо дахин гаргах боломжтой.

- Буцаан төлөх эрхтэй бонд:

Энэ төрлийн бондын шинж чанар дээрх төрлийн эсрэг агуулгатай юм: Тухайлбал зах зээлийн хүү буурах биш өсч жилийн 20 хувьд хүрвэл бонд

эзэмшигч маань хугацаанаас өмнө компанид бондыг буцаан өгч үндсэн төлбөр буюу мөнгөө аваад илүү өгөөжтэй хөрөнгө оруулалтыг сонгоно.

### 3. Бондын үнэлгээ, өгөөж

Аливаа хөрөнгө оруулалтын үнэ цэнийг тооцохдоо тухайн хөрөнгө оруулалтын ирээдүйд олох нийт орлогын өнөөгийн үнэ цэнэ буюу мөнгөний өнөөгийн үнэ цэнийг тооцох аргыг ашигладаг. Бондын хувьд ирээдүйд үндсэн төлбөр болон хүүгийн төлбөр гэсэн 2 төрлийн мөнгөн урсгал тооцогдоно. Иймд бондын өнөөгийн үнэ цэнийг тооцохдоо 2 төрлийн мөнгөн урсгалын ирээдүйн орлогоос хамааруулан дараах томъёогоор тооцно.

$$P = \frac{C}{(1+r)^t} + \frac{M}{(1+r)^n}$$

- C - бондын хүү (төгрөгөөр)
- M - бондын нэрлэсэн үнэ
- r - бондын хүүгийн хувь хэмжээ
- n - бондын хугацаа (жилээр)
- P - бондын үнэ

#### Бондын өгөөж

Бондын өгөөжийг одоогийн өгөөж, дуусах хүртэл хугацааны дундаж өгөөж гэж 2 ангилдаг.

Одоогийн өгөөж (current yield) гэдэг нь бондын зах зээлийн үнэ, бондын хүүгийн хоорондын хамаарлыг илэрхийлдэг бол дуусах хүртэл хугацааны дундаж өгөөж (yield to maturity) нь үлдсэн бух хугацааны өгөөжийн жигнэсэн дунджаар илэрхийлэгддэгээрээ ялгаатай.

Current yield буюу одоогийн өгөөж нь тухайн бондын хүүг тухайн өдрийн үнэд харьцуулсан харьцаа юм. Дор одоогийн өгөөж олох томъёог жишээний хамт үзүүлэв.

## Бондын өгөөж (Bond Yield)

$$\text{Current Yield} = \text{Interest} / \text{Price} * 100\%$$

Жишээ:

Бондын нэрлэсэн үнэ 1000 \$, жилийн хүү 10 %, зах зээлийн үнэ 900 \$ бол бондын өгөөжийг тооц?

$$1000 \$ \cdot 10\% = 100 \$$$

$$1000 \$ : (100 \$ / 900 \$) \cdot 100\% = 11.1 \%$$

- Зах зээлийн үнэ 1100 \$, бондын өгөөж = ?

12

Бондын үнэлгээний томъёоноос yield to maturity-г олж болох бөгөөд тэг хүүтэй бондын хувьд авч үзвэл өгөөж нь дараах томъёогоор илэрхийлэгдэнэ.

$$Y = \frac{M}{P} \cdot \frac{1}{n} - 1$$

M - бондын нэрлэсэн үнэ

Y - бондын өгөөж

n - бондын хугацаа (жилээр)

P - бондын үнэ